



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 385

танай _____-ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Б.МӨНХТҮВШИН ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Бие даан нэр дэвшигч Б.Мөнхтүвшиний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа 2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Б.Мөнхтүвшиний Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


00607677

Бие даан нэр дэвшигч Б.Мөнхтүвшиний мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

Хувийг:Аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

**БУЛГАН АЙМГИЙН 2020 ОНЫ ИТХ-ЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БАЯРАА ОВОГТОЙ МӨНХТҮВШИНГИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



2020 оны 07 дугаар сарын 24

Монгол улсын үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль, болон бусад хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж аймгийн эдийн засаг хөгжлийн бодлогыг зүй зохистой гангаж төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах иргэдийн язгуур эрх ашгийг дээдлэж ажилтай орлоготой болгож амжиргааг нь дээшлүүлнэ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад нийцүүлэн дараах мөрийн хөтөлбөрийг боловсруулав. дор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэх болно. Үүнд:

Нэг. Аймгийн хөгжил, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, засаглалын чиглэлээр:

1.1 Тогтвортой засаглалыг хангах, төрийн бодлого залгамж чанар, сум орон нутгийн уялдааг хангахад чиглүүлэн, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт болон иргэдэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлтөд иргэдийн оролцоог ханган ажиллана. Аймгийн өрсөлдөх чадварын үнэлгээг дээшлүүлнэ.

1.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай хөгжлийн бодлогыг сум, аймгийн түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой, шуурхай төрийн үйлчилгээний чанарыг сайжруулсан тогтвортой засаглал төлөвшсөн орон нутгийн манлайллыг хангасан аймаг, сум болгоход дэмжин ажиллана.

1.3.Шударга, ил тод, иргэний эрх, эрх чөлөөг хангах хүнд сурталгүй, төрийн үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, хууль тогтоомжийн хэрэгжилтэд онцгойлон анхаарч, төрийн албаны мерит зарчмыг баримтлан дэмжинэ.

Хоёр. Эдийн засгийн чиглэлээр:

2.1. Булган аймгийн ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, тэгш хүртээмжтэй, шударга ил тод байх бодлогыг дэмжинэ. Орон нутгийн төсвийн зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгө

оруулалт, худалдан авах ажиллагааны ажлын гүйцэтгэл, үр дүнд хөндлөнгийн хяналтыг сайжруулан ажиллана.

2.2. Булган аймгийн сурталчлан таниулах соёлын өв, түүхэн дурсгал, аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко, төрөлжсөн аялал жуулчлалыг хөхиүлэн дэмжин, бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулан шинээр нэвтрүүлэх бодлогыг дэмжиж ажиллана. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, ногоон хөгжлийн бодлогыг дэмжиж ажиллана.

2.3. Малчин өрх, газар тариалан, хөдөө аж ахуй, дэд бүтэц, үйлдвэрлэл, худалдаа, бизнес эрхлэгчдийн ажиллах орчин, татвар, эдийн засгийн зээл, тусламж, хөнгөлөлт, урамшуулалд хамруулахад тэгш хүртээмжтэй, ил тод байх зарчмыг баримтлан дэмжинэ. олон улсын жишигт нийцсэн техник, технологи нэвтрүүлэх, төр хувийн хэвшлийн сайн түншлэлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлд анхаарч, дэмжиж ажиллана.

Гурав.Нийгмийн бодлогын чиглэлээр:

3.1. Сургууль, цэцэрлэгийн сургалтын орчинг сайжруулж, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээнд шаардагдах хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ зэрэгт онцгойлон анхаарна.

3.2. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг аялал жуулчлал, байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр дэмжин, сургалтын агуулга чанарт өөрчлөлт оруулах бодлогыг шинээр нэвтрүүлэн дэмжин ажиллана.

3.3. Эмнэлгийн чанар, хүртээмжид суурилсан нарийн мэргэжлийн оношлогоо шинжилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр тоног төхөөрөмж болон хүний нөөцийг чадавхжуулахад дэмжин, эрүүл Булган дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн, иргэдийн амьдралын зөв дадлыг дэмжсэн орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэн ажиллана

МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭСЭН,
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ:



Б.МӨНХТҮВШИН

1486071813

99966614



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 387.

танай _____-ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Л.ОДОНЧИМЭГ ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Л.Одончимэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа 2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Л.Одончимэгийн Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

006020609

Бие даан нэр дэвшигч Л.Одончимэгийн мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

Хувийг:Аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

БУЛГАН АЙМГИЙН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЛХАГВА ОВОГТОЙ
ОДОНЧИМЭГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР


Мөрийн хөтөлбөрийн үндсэн зорилго нь : Аймаг сумын дэд бүтэц, газар тариалан, ашигт малтмалын нөөц зэрэг давуу талуудад тулгуурлан, эдийн засгийн чадавхийг өсгөх бизнесийн орчинг дэмжсэнээр орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, өрхийн амжиргааг сайжруулан, хүний хөгжлийг дэмжиж ажиллахад оршино.

Би " **Хөгжлийн төлөө хамтдаа** " гэсэн уриаг дэвшүүлж, аймаг, сумын хөгжил, ард иргэдийн ирээдүйдээ итгэлтэй амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг иргэдийн санал хүсэлт дээр үндэслэн боловсруулсан.

Зорилт : Орон нутгийн хуралд иргэний төлөөллийг нэмэгдүүлснээр иргэдийн санал бодлыг бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд шууд хүргэж, ИТХ-аас гарч буй бодлого шийдвэрийг намын талцал намчирхалаас ангид, иргэдэд нээлттэй тэдний оролцоотой гаргаж, аймаг сумаа хөгжүүлэхэд оршино.

Мөрийн хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэх ба орон нутгийн иргэдийн эрх ашгийг нэн түрүүнд тавих тэднийг амжилтад хүргэх , ашиг орлогоо дээшлүүлэхэд чиглэсэн бодит ажлуудыг санал болгож байна.

1. Хэт улстөржилт, намуудын талцал, засаглалын хямралаас зайлсхийж, иргэдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх, Иргэдийн төлөөлөлгчдийн хурлын төлөөллийн ардчиллын тэгш зарчмыг баримтлан ажиллана.
2. Баяннуур сумын бизнес, эдийн засгийн хөгжлийн гарцыг тодорхойлох ,орон нутгийн хөгжлийн урт хугацааны бодлого төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг иргэдийн саналыг үндэслэн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
3. Ингэснээр орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх жижиг болон дунд бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
4. Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан болон бусад сангийн хөрөнгийн зарцуулалтыг нээлттэй болгож, иргэдийн санал санаачилга дээр тулгуурлан суманд тодорхой бизнес үйлдвэрлэл, ажлын байр бий болгоход чиглүүлнэ.
5. Төсөв, мөнгө, боловсон хүчний болон эд хөрөнгийн эрх мэдлийг бодитой шилжүүлэх хэрэгжүүлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлнэ.
6. Орон нутагт зарим атаршсан газар нутгуудын нөхөн сэргээлтийг эрчимжүүлж ашиг өгөх мод бут сөөг, хүнсний ногоо, ногоон тэжээл, эмийн ургамал тариалах зэргээр эргэлтэд оруулах бодлого хэрэгжүүлнэ.
7. Мөн хадлангийн талбайн ашиглах, сэргээх га-аас авах ургацыг нэмэгдүүлэх, өвс тэжээлийн хадгалалт хамгаалалт борлуулалт, хадланчдын нийгмийн асуудлыг



- шийдвэрлэхэд аймаг сум орон нутгийн засаг захиргаа болон, хадланчид, ТББ-уудтай хамтран тодорхой бодлого шийдвэр гаргуулж хэрэгжүүлж ажиллана.
8. Аймаг сумын бэлчээрийн даац хэтрэлт, нутгийн иргэдийн өвөлжөө хаваржаа бэлчээрийг хамгаалах, малын тоо толгойн зохист харьцааг барих чиглэлээр оторын бүс нутгийн захиргаа тухайн аймаг сумдын хурал захиргааны байгууллагуудтай хамтран дүрэм журам боловсруулан хэрэгжүүлэх ажлыг хянаж мөрдүүлж ажиллахад анхаарна.
9. "Эрүүл мал- эрүүл хүнс" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аймаг сумандаа орон нутгийн малын үүлдэрлэг байдлыг сайжруулахад анхаарч адууны угшилыг сайжруулах, мах сүү ноос ноолуурын чиглэлийн үхэр хонины ямааны суурь үүсгэх зэргээр ажиллана. Мөн мал эмнэлэгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг зорьж ажиллана.
10. Аялал жуулчлалын бодлого боловсруулж, байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах замаар эко аялал жуулчлалыг хөгжүүлж үүгээр дамжуулан малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх орон нутгийн соёлын түүхт дурсгалт газруудыг зохистойгоор сурталчилан таниулж, хадгалан, хамгаалан авч үлдэхэд анхаарч "Аялал жуулчлалын цогц бодлого" батлуулж ажиллана.
11. Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, мэргэж амьтантай тэмцэх замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ. Бэлчээрийн даац, төлөв байдлын судалгаанд тулгуурлан эдийн засгийн оновчтой хөшүүргийг ашиглан малын тоо, төрөл, сүргийн зохистой бүтцийг тогтоох, ашиглагдахгүй байгаа бэлчээрт худаг гаргах замаар бэлчээр усжуулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарна.
12. Сумын бизнес төлөвлөгөө боловсруулж, орон нутгийг аж ахуйн аргаар хөгжүүлэх, гахай тахиа жимс ногооны, өрхийн хоршоолол аж ахуй иргэдийг дэмжиж, эцсийн бүтээгдэхүүн гаргах зах зээлд нийлүүлэх боломжийг судлана.
13. Цөлжилттэй тэмцэх орон нутгийг ойжуулах чиглэлээр модны төрөл зүйлийг нэмэгдүүлэх, услалтын системийг боловсронгуй болгох, модны амьдралтын хувийг нэмэгдүүлэх, гол нуур, мод бут сөөгийг хамгаалах чиглэлээр байгаль орчныг хамгаалах бодлого боловсруулан уламжилж ажиллана. Мөн мод бут суулгац тариалж буй иргэд аж ахуй нэгжийг зах зээлд дэмжих ажлыг эхлүүлнэ.
14. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх боломжтой ажлуудын судалгааг гаргаж төсөвт суулгахад анхаарч аймгийн ИТХ-ын хуралдаанаар санал оруулж ажиллана.
15. Гадаад дотоодын болон олон улсын хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрийг орон нутагтаа татан төвлөрүүлэх ажлыг аймаг сум орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулна.

Л. 

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Өндөр настны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдах, эмийн нөөцийг нэмэгдүүлэх, тэдний чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж бололцоог хангах нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого боловсруулж ажиллана.
2. Залуу гэр бүлийг дэмжих зорилгоор бага өртөгтэй орон сууцыг барьж орон сууцжуулах, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжийг судлана.
3. Малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, мал мах гадаад дотоод зах зээлд гаргах арьс шир түүхий эд, сүү цагаан идээг боловсруулах үйлдвэрийг бүсчилэн байгуулахад аймгийн ИТХ-д өөрийн санал санаачлагыг гаргана.
4. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжиж, орон нутагтаа үйлдвэрлэл эрхлэх гарааны бизнес эрхлэх боломжийг бий болгож бизнес эрхлэгч нарыг бодлогын түвшинд дэмжин ажиллана.
5. Амьдралын түвшин доогуур орлоготой болон, өрхийн орлого бага иргэдэд малжуулах гэржүүлэх хөтөлбөрийг нэмэгдүүлэх ядуурлыг бууруулахад чиглэгдсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтийг татах, тусламжийг зохицуулах, оновчтой зарцуулах, түүнд тавих хяналтыг сайжруулна.
6. Төрийн албан хаагчдын "Нийгмийн баталгааг хангах" цогц хөтөлбөрийг сумын ИТХ-аар батлуулан тэдний эрүүл мэнд, мэдлэг боловсролоо дээшлүүлэх чадвархижуулах, нийгмийн асуудлаа шийдвэрлэх нөхцөл боломжийг хангахад хамтарч ажиллана.
7. Улаанбаатар хотод сурч байгаа оюутан залуусын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тэдний чөлөөт цаг өөрийгөө хөгжүүлэх боломжийг хангахад анхаарч ажиллана. Эргэн төлөгдөх нөхцөлтэй хүүгүй сургалтын зээлийн сан бий болгоход анхаарна.
8. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны түншлэлийн гэрээг байгуулж орон нутагт НӨУЁБ болон ТББ-уудын хамтын ажиллагааг өргөтгөн ажиллахад анхаарна.
9. ИТХ-ын төлөөллийн хувьд нутгийн зөвлөл нутгийн уугуул иргэдтэй хамтран орон нутгийн хөгжлийн цогц төлөвлөгөөг хамтран боловсруулж хэрэгжүүлж ажиллана.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан.....Л.Одончимэг



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 388

танай _____ -ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Д.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Д.Хишигжаргалын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа 2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


Бие даан нэр дэвшигч Д.Хишигжаргалын Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


006020619

Бие даан нэр дэвшигч Д.Хишигжаргалын мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.


Хувийг:Аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



БУЛГАН АЙМГИЙН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАМБА ОВОГТОЙ
ХИШИГЖАРГАЛЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Мөрийн хөтөлбөрийн үндсэн зорилго нь : Булган аймгийн дэд бүтэц, газар тариалан, ашигт малтмалын нөөц зэрэг давуу талуудад тулгуурлан, эдийн засгийн чадавхийг өсгөх бизнесийн орчинг дэмжсэнээр орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, өрхийн амжиргааг сайжруулан, хүний хөгжлийг дэмжиж ажиллахад оршино.

Би "Намчирхаж биш нутгархаж хөгжье" гэсэн уриаг дэвшүүлж, аймаг, сумын хөгжил, ард иргэдийн ирээдүйдээ итгэлтэй амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулсан.

Зорилт : Орон нутгийн хуралд иргэний төлөөллийг нэмэгдүүлснээр иргэдийн санал бодлыг бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд шууд хүргэж, ИТХ-аас гарч буй бодлого шийдвэрийг намын талцал намчирхалаас ангид, иргэдэд нээлттэй тэдний оролцоотой гаргаж, аймаг сумаа хөгжүүлэхэд оршино.


Мөрийн хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэх ба "мөнгөн бус" орон нутгийн иргэдийн эрх ашгийг нэн түрүүнд тавих тэднийг амжилтад хүрэх, ашиг орлогоо дээшлүүлэхэд чиглэсэн бодит ажлуудыг санал болгож байна.

1. Хэт улстөржилт, намуудын талцал, засаглалын хямралыг арилгаж, иргэдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлнэ.
2. Булган аймгийн бизнес, эдийн засгийн хөгжлийн гарцыг тодорхойлж, бизнесийн бие даасан бодлого боловсруулах, жижиг дунд бизнесийг дэмжиж, шууд борлуулалтын худалдааны эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
3. "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтыг нээлттэй болгож, иргэдийн санал санаачлага дээр тулгуурлан суманд тодорхой бизнес үйлдвэрлэл, ажлын байр бий болгоход чиглүүлнэ.
4. Төсөв, мөнгө, боловсон хүчний болон эд хөрөнгийн эрх мэдлийг бодитой шилжүүлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангана.


5. Орон нутагт хамгийн хурцаар тавигдаж байгаа атаршсан газар нутгуудын нөхөн сэргээлтийг эрчимжүүлж ашиг өгөх бут, сөөг, эмийн ургамал тарьж түүнийг эргэлтэнд оруулна.
6. Мөн газар тариалангийн бүс нутгийн газрын төлөв байдал, чанарыг бууруулахгүйгээр эдийн засгийн эргэлтэнд оруулж, тариаланчид ногоочидыг дэмжих бодлого баримтлана
7. Аялал жуулчлалын бодлого боловсруулж, байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах замаар эко аялал жуулчлалыг хөгжүүлж үүгээр дамжуулан малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх орон нутгийн соёлын түүхт дурсгалт газруудыг зохистойгоор сурталчилан таниулж хадгалан хамгаалан авч үлдэхэд анхаарна.
8. "Мал эрүүлжүүлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлж аймаг сумандаа орон нутгийн малын үүлдэрлэг байдлыг сайжруулахад анхаарч адууны угшилыг сайжруулах, мах сүү ноос ноолуурын чиглэлийн үхэр хонины ямааны суурь үүсгэх зэргээр ажиллана. Мөн мал эмнэлэгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай малын эм, эмийн бүтээгдэхүүний хангалтанд анхаарна.
9. Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, мэрэгч амьтантай тэмцэх замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ. Бэлчээрийн даац, төлөв байдлын судалгаанд тулгуурлан эдийн засгийн оновчтой хөшүүргийг ашиглан малын тоо, төрөл, сүргийн зохистой бүтцийг тогтоох ашиглагдахгүй байгаа бэлчээрт худаг гаргах замаар бэлчээр усжуулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.
10. Булган аймгийн сумдын бүсчлэн хөгжүүлэх бизнес төлөвлөгөө боловсруулж, малчин, тариаланч өрхийн хоршоолол аж ахуй дэмжиж малын болон тариалангийн аж ахуйн түүхий эдийг боловсруулах, хадгалах, борлуулах, боловсруулах эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бий болгоно.
11. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх боломжтой ажлуудын судалгааг гаргаж төсөвт суулгахад анхаарч аймгийн ИТХ-ын хуралдаанаар санал оруулж ажиллана.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

12. Өндөр настны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдах, хөнгөлөлттэй эмийн нөөцийг нэмэгдүүлэх, тэдний чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж бололцоог хангах нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого боловсруулж ажиллана.
13. Залуу гэр бүлийг дэмжих зорилгоор бага өртөгтэй орон сууцыг барьж орон сууцжуулах, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжийг судлана.



14. Малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, мал махыг боловсруулан гадаад дотоодын зах зээлд гаргах, малын түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг бүсчилэн байгуулахад өөрийн санал санаачлагыг гаргана.
15. Аймаг сумын жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжиж, орон нутагтаа үйлдвэрлэл эрхлэх гарааны бизнес эрхлэх боломжийг бий болгож бизнес эрхлэгч нарыг дэмжин ажиллана.
16. Амьдралын түвшин доогуур орлоготой болон, өрхийн орлого бага иргэдэд зориулсан бичил санхүүгийн үйлчилгээ болон бага хүүтэй төсөл хөтөлбөрийн зээлийн санг бий болгох, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтийг татах, тусламжийг зохицуулах, оновчтой зарцуулах, түүнд тавих хяналтыг сайжруулна
17. Төрийн албан хаагчдын "Нийгмийн баталгааг хангах" цогц хөтөлбөрийг сумын ИТХ-аар батлуулан тэдний эрүүл мэнд, мэдлэг боловсролоо дээшлүүлэх чадвахижуулах, нийгмийн асуудлаа шийдвэрлэх нөхцөл боломжийг хангахад хамтарч ажиллана.
18. Улаанбаатар хотод сурч байгаа оюутан залуусын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тэдний чөлөөт цаг өөрийгөө хөгжүүлэх боломжийг хангахад анхаарч ажиллана.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан  Д.Хишигжаргал



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 389

танай _____-ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Г.ЧОЙЖАМЦ ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Г.Чойжамцын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа 2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Г.Чойжамцын Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


006000

Бие даан нэр дэвшигч Г.Чойжамцын мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

Хувийг:Аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

БУЛГАН АЙМГИЙН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГАНБАТ ОВОГТОЙ
ЧОЙЖАМЦЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020.07.22

Мөрийн хөтөлбөрийн үндсэн зорилт нь: Аймгийн ИТХ-д бие даан нэр дэвшиж, төлөөлөгчөөр сонгогдсоноороо намын харъяалалгүй иргэний төлөөлөлийг нэмэгдүүлж, орон нутаг дахь хуулийн хэрэгжилт, ИТХ, түүний тэргүүлэгчид, Засаг дарга, түүний тамгын газраас гаргаж буй бодлого шийдвэрүүдэд иргэний хяналтыг тавьж намын талцал намчирхалаас ангид, шууд ардчилалын зарчмаар иргэдийн оролцоог ханган, хурлын төлөөлөгчийн эрх мэдлийн хүрээнд сум орон нутгийн өмнө тулгамдаж буй тодорхой асуудлуудыг бодлого тодорхойлох шийдвэр гаргах түвшинд хүргэж ажиллахад оршино.

Сайхан сумын дэд бүтэц, аялал жуулчлал, ашигт малтмалын нөөц, онцлог бүтээгдэхүүн зэрэг давуу талуудад тулгуурлан, эдийн засгийг чадавхийг өсгөх бизнесийн орчинг дэмжсэнээр хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, өрх гэрийн амьдралын чанарыг сайжруулах, хүний хөгжлийг дэмжиж, аймаг сумаа хөгжүүлэхэд бодлого тодорхойлон ажиллахад оршино.

Иймд би "ҮНДЭСНИЙ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ ӨРХ БҮР ХӨГЖҮҮЛБЭ" уриаг дэвшүүлж, аймаг, сумын хөгжил, ард иргэдийн ирээдүйдээ итгэлтэй амьдралын нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.


- Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцлийг бүрдүүлэх
- Ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- Байгаль орчинд зохицсон эдийн засгийн өсөлт бүтцийг бий болгон хөгжүүлэх

нэг. Булган аймгийн Сайхан сумын хөгжлийн гарцыг тодорхойлж, эдийн засгийн орчинг сайжруулах

- Сайхан сумын давуу тал болох Монголын хамгийн сайхан амттай айргийг их хэмжээгээр эдийн засгийн эргэлтэнд оруулах, хөгжүүлэх, эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлж өрх бүрийг үйлдвэрлэгч болгох,
- "Хөхүүрийн Айраг" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Булган аймгийн Сайхан сумын малчдын үйлдвэрлэсэн айргийг савлагаатай, илүү боловсронгуй болгож Монгол орны өнцөг бүрт, дэлхийн улсуудад (АНУ-ын Чикаго хотруу гарсан) зэрэгт худалдаалах эдийн засгийн боломжийг бий болгох,
- Сайхан сумын давуу тал болох Монголын хамгийн олон адууг түшиглэн Аялал жуулчлалын Үндэсний хэмжээний арга хэмжээ "Nomadic Horse Festival /Нүүдэлчдийн Адууны Наадам/"-г жил бүрийн 7,8-р саруудад Булган аймагт зохион байгуулдаг болох,

хоёр. Өрхийн амьжиргааг дэмжиж ажлын байр бий болгох

- Сайхан сумын өрх бүрийг АЙРАГ үйлдвэрлэх ажилд уриалж адуугүй, цөөн адуутай айлууд нь олон адуутай айлуудын айраг үйлдвэрлэх ажилд хамтрах



зарчмаар бизнесийн түншлэлийг зохион байгуулж ажлын байрыг нэмэгдүүлэх,

- Өрхийн аж ахуй эрхлэдэг, жижиг дунд бизнес эрхлэгчдэд чиглэсэн төсөл хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, ажлын байрны таатай орчин бүрдүүлэх тал дээр анхаарах,
- Ядуу айл өрх, иргэдэд зориулсан бичил санхүүгийн үйлчилгээг бий болгох, ядуурлыг бууруулж ажилгүйдлыг арилгахад чиглэсэн хөрөнгө оруулалт татах,

гурав. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангах, иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх

- "Орон нутгийн хөгжлийн сан", "Сум хөгжүүлэх сан"-гуудад хяналт тавьж, иргэдэд нээлттэй ил тод байдлыг бүрдүүлж ажилна.
- Гадаад дотоодын тусламжийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, ил тод оновчтой зарцуулах

дөрөв. Оюутан, залуучуудын дэмжиж ажиллах


- Улаанбаатар хотод суралцахаар очиж буй оюутнуудад суралцах, амьдрах тав тухтай орчин бүрдүүлэх чиглэл барих,
- Оюутны сургалтын төлбөрийг дэмжих "ХӨХҮҮРИЙН АЙРАГ САН" байгуулж зун айраг үйлдвэрлэх ажилд идэвхтэй ажилласан оюутнуудад хөнгөлөлттэй зээл олгодог болох,
- Залуучуудыг малжуулах /адуужуулах/, айраг үйлдвэрлэх ажилд уриалж тэдэнд зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Сумандаа ажиллаж амьдарч байгаа залуусыг боловсролын болон бусад чиглэлээр сургалт, хөтөлбөрт хамруулж хамтран ажиллах,
- Аялал жуулчлалын "Нүүдэлчдийн Адууны Наадам" арга хэмжээний зохион байгуулалтанд зориулж оюутан, залуучуудыг тусгай сургалтанд хамрагдуулж чадваржуулах, /англи хэл, зочлох үйлчилгээ, хөтөч, морин цирк, үйлчилгээ харилцааны соёл гэх мэт/

тав. Мал аж ахуйг хөгжүүлэх, малчдын амьжиргааг дээшлүүлэх

- Малжуулах төсөл хөтөлбөрт малчдыг идэвхитэй хамруулж үр дүнг тодорхойлж ажиллах,
- Сумдыг бүсчлэх хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд мал махыг экспортод гаргаж түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох тал дээр Булган аймгийн хэмжээнд хамтран ажиллах,
- Малын үйлдвэр угсааг сайжруулах, малын удмын санг эрүүлжүүлэх тал дээр анхаарч стандартын малын эмнэлгийн үйлчилгээг нэвтрүүлж, малын чанартай эм бэлдмэлийн бөөний худалдааг бий болгох,


Зургаа. Соёл, Боловсрол, Эрүүл мэндийн чиглэлээр

- Сургуулийн өмнөх болон суурь боловсролын сургуулийн сургалтын матриаллаг бааз, суралцах орчинг сайжруулах чиглэлээр бодлого хөтөлбөр боловсруулж ажиллана.



- "Эрүүл малчин" хөтөлбөр хэрэгжүүлж малчдын эрүүл мэндийн цогц үзлэг шинжилгээнд бүрэн хамруулж, суурь өвчлөлийн болон эрт илрүүлэлтийн арга хэмжээг авч ажиллахад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- МУ-ын Засгийн газар 2019 онд "Хөхүүрийн айраг эсгэх соёлыг"-ыг ЮНЕСКО-т бүртгүүлсэн түүхэн үйл явдлыг Сумын бахархалт үйл явдал болгож, айл өрх бүр хөхүүрт айраг эсгэж, хөх савнаас татгалзах, үүнийг орлох хүний биед сөрөг нөлөөгүй хүнсний зориулалттай саваар солих уриалгыг ажил болгох,

Мөрийн хөтөлбөр боловсруулсан

 Т. Чайминг



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.24 № 341

танай _____-ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 4-Р ТОЙРОГТ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Я.ГЭРЭЛТ
ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Бие даан нэр дэвшигч Я.Гэрэлтийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа 2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эсвэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Я.Гэрэлтийн Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


006020516

Бие даан нэр дэвшигч Я.Гэрэлтийн мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

Хувийг:Аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Д.АНХБАЯР

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН 4-Р ТОЙРОГТ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ЯНЖИНСҮРЭН ОВОГТОЙ ГЭРЭЛТИЙН

“САЙН ЗАСАГЛАЛ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР




БУЛГАН АЙМАГ
2020 ОН



АГУУЛГА

ОРШИЛ	2
УХААЛАГ ЗАСАГЛАЛ	2
ЧАДВАРЛАГ ЗАСАГЛАЛ	3
АЙМГИЙН САЙН ЗАСАГЛАЛ	3
ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ ЗАСАГЛАЛ	4



ОРШИЛ

Би та бүхэнд санал болгож буй мөрийн хөтөлбөрөө "САЙН ЗАСАГЛАЛ" гэж нэрлэлээ.

Учир нь:

Миний бие Төрийн болон Хувийн хэвшлийн засаглалаар олон төрлийн судалгаа хийж зөвөлгөө өгч ажиллаж байна



Бүхий л салбарын хөгжлийн гол суурь асуудал нь засаглалын асуудал болоод байгаа бөгөөд Сайн засаглалыг бий болгож чадвал Төр, засаг хөгжлийг гацаагч биш жинхэнэ утгаараа хөтөлгөч, хөдөлгөгч хүч болж бусад салбарын бодлого, үйл ажиллагаанд зэрэгээр нөлөөлж, нийгмийн бүхий л хүрээнд тогтвортой байдлыг үүсгэж, хүний хөгжил, ажлын байр, бизнесийн орчин, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын чанар, ядуурал зэрэг асуудлыг бүрэн шийдэх боломж бүрдэнэ.

Засаглал нь дан ганц компани, засгийн газар, төрийн байгууллагуудын удирдлагаар хэмжигддэг уламжлалт хандлага шинэчлэгдэн, засаглалын үйл явцад иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог хангахыг чухалчлах болсон. Өөрөөр хэлбэл төр дангаараа хөгжлийг удирдан чиглүүлж, хэрэгжүүлэх бус төр, иргэн, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоотой хамтын үйл ажиллагаа гэж ойлгож болно. Үүнийг Монгол Улсад хүний хөгжлийг хангах сайн засаглалын суурь арга зүй болгон авч үзэж байна.


1. УХААЛАГ ЗАСАГЛАЛ

ЗОРИЛТ: Аймгийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана. Төр захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчлана.

ҮР ДҮН: Аймгийн удирдлагын үйл ажиллагаа сайжирч, доод шатны албан тушаалтнуудын ажил үүрэг тодорхой болж ард иргэдийн хүлээлтээс давсан үр дүнд хүрнэ.

- 1.1 Иргэдийн төлөөлөгчид сонгогдсон гишүүдэд иргэд нь хариуцлага тооцдог зохицуулалтыг бий болгож, Иргэдийн төлөөлөгчидөд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эргүүлэн татах улс төрийн зөрөг соёл, хандлагыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.2 Аймаг, сумын түвшинд үзүүлэх төрийн үйлчилгээг тодорхойлж, шат дамжлагыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарна.
- 1.3 Аймгийг бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн орон нутгийн өмчтэй, татварын боловсронгуй тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдэлтэй аймаг болгохыг зорж ажиллана.
- 1.4 Цахим системийг хөгжүүлж, төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох боломжийг бүрдүүлнэ. Төр хувийн хэвшлийн дэвшилтэт техник технологи автоматжуулалтыг бүрэн дүүрэн дэмжинэ.
- 1.5 Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, мал аж ахуй, зэрэг аймгийн тэргүүлэх салбарт, дэвшилтэт болон шинэ техник технологи, бүтээгдэхүүн

үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжиж ажиллана.



2. ЧАДВАРЛАГ ЗАСАГЛАЛ

ЗОРИЛТ: Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.

- 2.1 Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд суурилсан, түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх иргэн төвтэй төрийн үйлчилгээний стандарт боловсруулахад дэмжиж ажиллана.
- 2.2 Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлд анхаарч ажиллана.
- 2.3 Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, ажлын үр дүнгээс хамаарч шатлан дэвших зарчмыг баримтлана.
- 2.4 Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоонд бүрэн шилжүүлэхийг дэмжинэ.
- 2.5 Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөөх, сэлгэн ажиллуулах, тур томилох, сургаж хэгжуулэх бодлого, зохицуулалтыг чадахуйн буюу мерит зарчимд бүрэн нийцсэн байхыг дэмжинэ.
- 2.6 Төрийн албан хаагчийн нэр хундийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, амьдралын баталгаагаар хангах зохистой тогтолцоо төлөвшүүлэхэд анхаарна.

3. АЙМГИЙН САЙН ЗАСАГЛАЛ

Булган аймаг нь ажлын чадварлаг хүний нөөц дутагдалтай, хөгжлийн бүхий л үзүүлэлтээр сүүл мушгиж, анхдагч хэрэгцээ болох орон байр нь халуун усгүй, дулааны доголдолтой зэрэг олон асуудал тулгараад байна. Байгалийн үзэсэлэнт бүрдсэн нутаг хэдий ч аялал жуулчлал хөгжөөгүй, эдийн засгийн чадавхи сул аймаг байсаар байна. Шинээр буй болсон үйлдвэр байхгүй ажлын байр хомс ядуурал ажилгүйдэл их зэрэг шийдэлээ хүлээсэн олон асуудал байна.

Аймгийн төвийн хүн амын амьдралыг зохицуулсан, иргэд оршин суугчиддаа чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх аймгийн дүрэм, стандартыг бий болгож, тулгамдсан асуудлаа өөрийн онцлогт тохируулан шийдвэрлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.


3.1 Аймгийн төвийн нэгдсэн стандарттай болгож иргэдийн сурч хөдөлмөрлөх, аюулгүй орчинд ажилд амьдрах, зорчих орчны аятай таатай нөхцлийг бий болгохыг хичээн ажиллана.

4. ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ ЗАСАГЛАЛ

ЗОРИЛТ: Хүн бүр чанартай боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах, нийгмийн халамжид хамрагдах, хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлэхыг зорин ажиллана.

Сургуулийн насны хүн амын тооны өсөлтөнд тулгуурлан бүх шатны сургалтын байгууллагын дэд бүтэцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй орчин бий болгож чанартай үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарна.

- 4.1 Аймгийн хүн амын амьдарлын зөв дадал хэвшлийг дэмжиж, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хороодын хамтын ажиллагааг сайжруулахад анхаарна.
- 4.2 Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцвэржүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй "Үйлчлүүлэгч төвтэй" тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг дэмжих бодлого баримтлана.
- 4.3 Өрхийн амжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрт хүрэх нийгмийн бодлого, зорилтот бүлэгт үзүүлэх халамж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.4 Залуучуудийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжиж ажиллана.
- 4.5 Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж бусад аймагтай ижил түвшинд хүргэхийг зорьж ажиллана.
- 4.6 Гадны өндөр хөгжилтэй улс орнуудад сурч, гэрээгээр болон хувиараа хөдөлмөрлөж байгаад эх орондоо эргэн ирсэн иргэдийн мэдээллийн санг бий болгож, тухайн улс оронд сурч, мэргэшсэн чиглэлээрээ хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарна.





**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 344
танай _____-ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ В.БАТТУЛГА ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн В.Баттулгын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 – 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудитын MNS 6817 – 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим Төрийн аудит MNS 6817 – 8 : 2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч В.Баттулгын аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", "Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

• 006020522

Бие даан нэр дэвшигч В.Баттулгын мөрийн хөтөлбөр /  хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Булган аймгийн Сонгуулийн хороонд
Хавсралт  хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.НХБАЯР



**БУЛГАН АЙМГИЙН 2020 ОНЫ ИТХ-ЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ВАНДАНСҮРЭН ОВОГТОЙ БАТТУЛГЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



2020 оны 07 дугаар сарын 24

Булган аймгийн газар нутгийн бүрэн бүтэн байдал, Монгол үндэстний нийтлэг үнэт зүйлийг хадгалах үндсэн зарчмыг баримтлан Булган аймагт эдийн засгийн өсөлтийг бий болгох, ядуурлыг бууруулах, орлогын тэгш бус байдлыг багасгах, боловсролын хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, экологийн тэнцэрт байдал, биологийн төрөл зүйлийг хадгалах бодлогыг хэрэгжүүлэх, ажил эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бодлогыг сум, аймгийн түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой, шуурхай төрийн үйлчилгээний чанарыг сайжруулсан тогтвортой засаглал төлөвшсөн орон нутгийн манлайллыг хангасан аймаг болгох ерөнхий зорилгын дагуу "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад нийцүүлэн дараах мөрийн хөтөлбөрийг боловсруулав. Үүний дагуу дараах чиглэлд дор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэх болно. Үүнд:

Нэг. Аймгийн хөгжил, өрлсдөх чадварыг дээшлүүлэх, засаглалын чиглэлээр:

1.1. Тогтвортой засаглалыг хангах, төрийн бодлого залгамж чанар, сум орон нутгийн уялдааг хангахад чиглүүлэн, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт болон иргэдэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлтөд иргэдийн оролцоог ханган ажиллана. Аймгийн өрсөлдөх чадварын үнэлгээг дээшлүүлнэ.

1.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай хөгжлийн бодлогыг сум, аймгийн түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой, шуурхай төрийн үйлчилгээний чанарыг сайжруулсан тогтвортой засаглал төлөвшсөн орон нутгийн манлайллыг хангасан аймаг, сум болгоход дэмжин ажиллана.

1.3. Шударга, ил тод, иргэний эрх, эрх чөлөөг хангах хүнд сурталгүй, төрийн үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, хууль тогтоомжийн хэрэгжилтэд онцгойлон анхаарч, төрийн албаны мерит зарчмыг баримтлан дэмжинэ.

Хоёр. Эдийн засгийн чиглэлээр:

2.1. Булган аймгийн ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, тэгш хүртээмжтэй, шударга ил тод байх бодлогыг дэмжинэ. Орон нутгийн төсвийн зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ажлын гүйцэтгэл, үр дүнд хөндлөнгийн хяналтыг сайжруулан ажиллана.

2.2. Булган аймгийн сурталчлан таниулах соёлын өв, түүхэн дурсгал, аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко, төрөлжсөн аялал жуулчлалыг хөхиүлэн дэмжин, бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулан шинээр нэвтрүүлэх бодлогыг дэмжиж ажиллана. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, ногоон хөгжлийн бодлогыг дэмжиж ажиллана.

2.3. Малчин өрх, газар тариалан, хөдөө аж ахуй, дэд бүтэц, үйлдвэрлэл, худалдаа, бизнес эрхлэгчдийн ажиллах орчин, татвар, эдийн засгийн зээл, тусламж, хөнгөлөлт, урамшуулалд хамруулахад тэгш хүртээмжтэй, ил тод байх зарчмыг баримтлан дэмжинэ. олон улсын жишигт нийцсэн техник, технологи нэвтрүүлэх, төр хувийн хэвшлийн сайн түншлэлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлд анхаарч, дэмжиж ажиллана.

Гурав.Нийгмийн бодлогын чиглэлээр:

3.1. Сургууль, цэцэрлэгийн сургалтын орчинг сайжруулж, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээнд шаардагдах хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ зэрэгт онцгойлон анхаарна.

3.2. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг аялал жуулчлал, байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр дэмжин, сургалтын агуулга чанарт өөрчлөлт оруулах бодлогыг шинээр нэвтрүүлэн дэмжин ажиллана.

3.3. Эмнэлгийн чанар, хүртээмжид суурилсан нарийн мэргэжлийн оношлогоо шинжилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр тоног төхөөрөмж болон хүний нөөцийг чадавхжуулахад дэмжин, эрүүл Булган дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн, иргэдийн амьдралын зөв дадлыг дэмжсэн орчин нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана

Мэдээллийг бэлтгэсэн,
бие даан нэр дэвшигч:

В. Баттулга

В.Баттулга

ГН88011713

99011891



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.04.23 № 324

танай _____ -ны № _____ т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ Б.УЯНГАБАТ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Б.Уянгабатын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 – 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудитын MNS 6817 – 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим Төрийн аудит MNS 6817 – 8 : 2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


Дүгнэлт

Б.Уянгабатын аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", "Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

006000500

“Б.Уянгабат бие даан нэр дэвшигч”-ийн мөрийн хөтөлбөр /᠘... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Булган аймгийн Сонгуулийн хороонд
Хавсралт ᠘... хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР

**БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ
ДААН НЭР ДЭВШИГЧ БАВУУДОРЖИЙН УЯНГАБАТЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**



Миний бие Булган аймгийнхаа нутгийн удирдлагын байгууллагад сонгогдвол дараах чиглэлээр ажиллана.

НЭГ. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ БУЛГАНЧУУД

1.1 Аймгийн боловсролын байгууллагын удирдлага, боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх, тэдний чадвар, чадамжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

1.2 Сургууль, цэцэрлэгүүдийн уялдаа холбоо, залгамж чанарыг бэхжүүлэхэд анхаарч ажиллана. СӨБоловсролоор тавигдсан хүүхдийн хөгжил төлөвшилтийг ЕБС-д хүүхэд бүрийн онцлогийг харгалзан залгамжлан хөгжүүлэх бодлого боловсруулахыг дэмжинэ.

1.3 Ахлах ангийн сурагчдын мэргэжил сонгох, элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлдэх тогтолцоог шинэ шатанд гаргаж, багш сурагчдын өрсөлдөөний сэтгэлзүйг дээшлүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.

1.4 ЕБС төгсөгчдийн инженерийн чиглэлийн болон баялаг бүтээгч мэргэжил сонгох хандлагыг дэмжиж ажиллана.

1.5 Боловсролын салбарт хувийн хэвшлийн боловсролын байгууллагын оролцоог дэмжихээс гадна гадаад улс орнуудаас сайн дурын, гэрээний үндсэн дээр ажиллах багш, боловсролын ажилтнуудын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

ХОЁР. ЭРЧИМТЭЙ ХӨДӨӨ АЖ АХУЙТАЙ БУЛГАНЧУУД

2.1. Малчид, тариаланчдын орлогын эх үүсвэр хөдөө аж ахуйн гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүний худалдааг ОХУ-ын хил залгаа бүсийн сүлжээтэй холбох санаачилгыг бодлого боловсруулах, гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд тусгуулж ажиллана.

2.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлээс нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн санаачилгыг дэмжиж ажиллана.

2.3. Газар тариалан, мал аж ахуйн зохистой харьцаа, уялдаа холбоог дээшлүүлнэ.

ГУРАВ. БАЙГАЛЬ ЭКОЛОГИ ТЭНЦВЭРТЭЙ БУЛГАНЧУУД

3.1. Булган нутгийн эрдэс баялгийг улс төр, бизнесийн бүлэглэлийн ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлж, баялгийг хууль бусаар өмчлөх аливаа үйлдэл эс үйлдэхүйтэй тууштай тэмцэнэ.

3.2. Булган хангайн байгалийн тогтоц, үзэсгэлэнт газруудыг түшиглэн дотоод, гадаадын аялал жуулчлалын шинэ маршрутуудыг бий болгоход санаачлагатай ажиллахын зэрэгцээ тухайн бүс нутгийн иргэдийн зочлох үйлчилгээний боловсролыг дээшлүүлэхэд анхаарна.

3.3. Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтанд авах, хур тунадас, гадаргын

ус хуримтлуулах технологи нэвтрүүлэх замаар аюулгүй усан хангамжийн бүтээн байгуулалтыг дэмжинэ.

3.4. Иргэдийн экологийн ухамсарыг дээшлүүлэх талаар уриалга гаргаж ажиллана.

3.5. Аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн байгалийн гаралтай бэлэг дурсгалын бүтээгдэхүүний гар урлал, уламжлалт зан үйлийн соёлын үзүүлбэрүүдийг бий болгох талаар санаачлагатай ажиллана.

ДӨРӨВ. ИРГЭД НЬ ХАНГАЛУУН БУЛГАНЧУУД

4.1. Булган аймгийн сумд эдийн засгийн хувьд бүсчлэгдэн, төрөлжин хөгжих бодлогыг дэмжинэ.

4.2. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, үйлдвэрлэл үйлчилгээ, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн гадаад дотоодын төсөл, хөтөлбөрүүдийн хувиарлалт, оновчтой байдал дээр хяналт тавьж ажиллана.

4.3. Сумдын төвд инженерийн байгууламж бүхий цэвэр бохир усны сүлжээнд холбогдсон орчин үеийн барилга байгууламж, хувийн, нийтийн орон сууцуудыг улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан байгуулж, тоноглохыг дэмжинэ.

ТАВ. ЭРҮҮЛ ЗАСАГЛАЛТАЙ БУЛГАНЧУУД

5.1. Аймаг, сумдын төрийн захиргааны байгууллага, төрийн үйлчилгээний албанд улс төрийн халгаа сэлгээ хийхээс сэргийлнэ.

5.2. Улс, орон нутгийн тендерийн шалгаруулалтанд иргэдийн зөвлөх үйлчилгээ хяналтыг төлөвшүүлнэ.

5.3. Хангал сум, Хялганат тосгоны нийгэм, эдийн засгийн харилцааг харилцан ашигтай, бие биенийхээ дутууг нөхөх, нэг сум, нэг ашиг сонирхол гэсэн байр суурьнаас хөгжилийн шинэ гарааг эхлүүлэх санал санаачлагыг идэвхтэй дэмжинэ.

БУЛГАН АЙМГИЙН ХАНГАЛ СУМЫН 4-Р БАГ, ХЯЛГАНАТ ТОСГОНЫ ИРГЭН



БАВУУДОРЖ ОВОГТОЙ УЯНГАБАТ

Утас: 99015834

РД: ФЖ72042554



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 343
танай _____ -ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ П.МАГСАР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн П.Магсарын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 – 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудитын MNS 6817 – 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим Төрийн аудит MNS 6817 – 8 : 2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


Дүгнэлт

П.Магсарын аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", "Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

006020500

“П.Магсар”-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.
Хувийг: Булган аймгийн Сонгуулийн хороонд
Хавсралт ... хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд
Булган аймгийн Баян-Агт сумаас Бие даан нэр дэвшигч Пүрэвсүрэн овогтой Магсарын мөрийн
хөтөлбөр



2020.07.03

1. Боловсрол

- 1.1 Багш мэргэжлийн үнэлэмж, Багшийн ур чадвар, заах аргыг сайжруулж боловсролын салбарын хүний нөөцийг бэхжүүлэх
- 1.2 Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулах, олимпиад, уралдаан тэмцээнүүдийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх
- 1.3 Сумын иргэдийн хэрэгцээнд нийцсэн насан туршийн боловсролын сургалт сурталчилгаа үйл ажиллагааг зохион байгуулах
- 1.4 Сургууль, цэцэрлэгийн гадна, дотно сургалтын орчныг тохижуулах, Сургууль, цэцэрлэгийг интензэтэд бүрэн холбох, "Цахим сургууль-Цахим сургалт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

2. Эрүүл мэнд


- 2.1 Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг орон нутагт эрчимжүүлэн, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх
- 2.2 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чадамжийг дээшлүүлж, тусламж үйлчилгээний тэгш хүртээмжтэй байдлыг хангаж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах
- 2.3 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эмнэлгээр үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн төвлөрөл, хүлээгдлийг бууруулах.
- 2.4 Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, рашаан, сувиллын үйл ажиллагааг өргөжүүлэх
- 2.5 "Эрүүл мэндийн хөтөч-2" дэд хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлнэ.
- 2.6 Хүн амыг аюулгүй чанарын баталгаатай эмээр жигд, хүртээмжтэй, тасралтгүй хангах
- 2.7 Эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах, нийгмийн баталгааг ханган мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх

3. Нийтийн биеийн тамир, спорт.

- 3.1 Тамирчдын хөгжих, уралдаан тэмцээнд оролцоход бүх талаар дэмжлэг үзүүлэхэд анхаарч тамирчдыг алдаршуулахад бодлогоор дэмжиж ажиллах
- 3.2 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэх.

4. Соёл, урлаг.

- 4.1 Соёл урлагийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соёлын үйлчилгээг шинэ шатанд гаргаж, Соёл урлагийн ажилтнуудыг сургах, давтан сургах ажлыг ээлж дараатай зохион байгуулж, мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлэх
- 4.2 Үндэсний уламжлал, өв соёлоо өвлүүлэх, хөгжүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж үндэсний наадгай сур харваа, шагай харвааг түгээн дэлгэрүүлэх холбоо, багуудыг дэмжиж ажиллах
- 4.3 Сумын номын сангийн орчин нөхцлийг сайжруулан үйл ажиллагааг өргөжүүлэх.



5. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалал.

- 5.1 Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын чиглэлээр төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоогүй сайжруулж, бодлогоор дэмжин хамтран ажиллах
- 5.2 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
- 5.3 Өрх гэр бүлийн гишүүдийн бодит байдлын судалгааг баг тус бүрээр нарийвчлан хийж, нэгтгэн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, аймгийн хүн амын хөгжлийн бодлого үйл ажиллагаанд тусгуулан хэрэгжүүлэх

6. Эдийн засгийн тогтвортой хөгжил

- 6.1 Орон нутгийн татварын бааз суурийг өргөтгөх, татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг шинэ шатанд хүргэн төсвийн орлогыг нэмэгдүүлэх.
- 6.2 Орон нутгийн төсвийн эх үүсвэрийг хамгийн оновчтой, үр ашигтай хуваарилж хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг ханган ажиллах
- 6.3 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд хяналт тавьж ажиллах.

7. Хөдөө аж ахуй

- 7.1 Мал үржлийн ажил үйлчилгээг сайжруулж, малын гаралтай түүхий эдийг уламжлалт болон дэвшилтэт технологиор боловсруулах замаар эдийн засгийн өсөлтийг ханган ажиллана.
- 7.2 Мал эмнэлгийн ажил үйлчилгээг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн чанартай, шуурхай болгож, гоц халдварт, халдварт өвчний тохиолдлыг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах чадварыг сайжруулан, малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагыг өндөржүүлж, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний чадавхийг өндөржүүлж, олон улсын худалдааны хориг бүхий халдварт өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлж, халдварт өвчингүй сум болох.
- 7.3 Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах замаар тогтвортой ажлын байр бий болгох
- 7.4 Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжийг бүрдүүлж, төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, аж ахуйн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- 7.5 Худалдаа, үйлчилгээний чанар, хэрэглээний аюулгүй байдлыг дээшлүүлэх, хэрэглэгчийг чанартай аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.
- 7.6 Төмс хүнсний ногоо тариаллах иргэдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

8. Байгаль орчин, аялал жуулчлал

- 8.1 Хүүхэд, залуучуудад экологийн боловсрол олгох хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх
- 8.2 Сумын төвд байгаль орчны хэсэг байгуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулах
- 8.3 Орчныг бохирдлоос хамгаалах бүх талын арга хэмжээг хэрэгжүүлж, аливаа төслийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгүүлсний үндсэн дээр дараагийн шатны үйл ажиллагааг үргэлжлүүлэх зарчмыг хэвшүүлэх

- 8.4 Орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалын эвент үйл ажиллагааг бренд болгон хөгжүүлж, гадаадын болон дотоодын аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, сурталчилгааг эрчимжүүлэх
- 8.5 Аялал жуулчлалын хөтөлбөр, маршрутыг нарийвчлан тогтоож, цахим хуудас нээж сурталчлах, сумын газарзүйн бүс нутаг онцлогт тохирсон аялал жуулчлалын чиглэлийг нээх
- 8.6 Хануй, Цагаан голын амралтын газрын байгаль орчныг хамгаалах
- 8.7 Тарвага, Буга, Согоо, Гөрөөс, Зэрлэг гахай гэх мэт ховордож байгаа ан амьтадыг хамгаалах

9. Шударга ёсны засаглал

- 9.1 "Алсын хараа-2050", "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал"-ын хүрээнд аймгийн "Хөгжлийн хэтийн зорилт" дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 9.2 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

10. Иргэн оролцсон шударга төр

- 10.1 Төрийн зөв бодлого, уламжлал шинэчлэлийн ударга засаглал бүхий залгамж холбоог өртөөлөн үргэлжлүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

11. Зөв удирдлага

- 11.1 Төрийн албанд хууль дээдэлдэг, зарчимч, үнэнч шударга, чадварлаг, зөв удирдлагыг тогтоож, сайн засаглалыг хэрэгжүүлэн, гадаад дотоодын хамтын харилцааг өргөжүүлнэ.